



МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

СОЁМБОМ ЭДЭЭ

№232 /441/ 2022.12.23

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

Г.САЙХАНБАЯР: ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ БҮР ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛИЙГ ӨӨРӨӨСӨӨ ЭХЛЭХ ХЭРЭГТЭЙ



Өнөөдөр ЗХЖШ 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлаа тайлагнаж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, бодлогоо тодотгохын зэрэгцээ алдаа оноо, амжилт бүтээлээ дүгнэлээ.

Эл хуралд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба тэргүүтэй БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд, Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн командлал, БИЦУГ,

нэгдсэн ажиллагааны удирдлага, төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил, цэргийн сургалт болон материал техникийн хангалтын тогтолцоог Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхэд чиглүүлэн боловсронгуй болгох,

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, дотоод хяналтыг нэмэгдүүлж, цэргийн албаны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зэрэг чиглэлийг баримтлан

2023 онд Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд Батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх,

Зэвсэгт хүчний бэлэн байдлыг дээшлүүлэх, байлдааны болон хуулиар хүлээсэн чиг үүргийг гүйцэтгэх чадавх, нэгтгэл, ангийн тайван цагийн орон тоогоор байлдааны үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх,

ЗХЖШ болон Төрлийн цэргийн командлалууд харьяа нэгтгэл, анги, салбаруудын зохион байгуулалтын бүтцийг бодит байдалд нийцүүлэн шинэчилж түүнд нийцсэн орон тоог батлан мөрдүүлэх

тасралтгүйгээр зохион байгуулах,

Бүх шатны төрийн байгууллагуудын үрэлгэн байдлыг хязгаарлаж, төсөв хөрөнгийг хэмнэх үүднээс Монгол Улсын Засгийн газраас баталсан Хэмнэлтийн тухай хуулийг бие бүрэлдэхүүн, алба хаагчид чанд мөрдөн ажиллахыг үүрэг болголоо.

Үүний дараагаар эзэмшсэн мэргэжилдээ эзэн нь болж бусад нөхдөө манлайлсан зарим офицер, ахлагч, ажилтан, алба хаагчдыг салбарын одон, медалиар шагнаж урамшуулав.

Төгсгөлд нь ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба 2022 оны үйл ажиллагаагаа амжилттай



ЦТГ-ын төлөөлөл, Улаанбаатар цэргийн хүрээний ангиудын захирагч нар оролцлоо.

ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр ЗХЖШ-ын 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсан юм.

ЗХЖШ нь 2022 оны үйл ажиллагааныхаа үндсэн зорилгыг "Зэвсэгт хүчний байгуулалтыг бэхжүүлэх, батлан хамгаалах төрийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлж, цэргийн удирдлагын байгууллага, нэгтгэл, ангийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх" хэмээн тодорхойлж дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

Тухайлбал, Зэвсэгт хүчний хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, Зэвсэгт хүчний стратегийн болон

ажилласан байна.

Батлан хамгаалахын сайд ЗХЖШ-ын үйл ажиллагааны тайланг танилцсаны дараа хэлсэн үгэндээ ЗХЖШ нь 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээгээ чанартай сайн гүйцэтгэн, амжилт бүтээлээр арвин байж мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх зорилгыг хангахад ахиц гарган ажилласныг онцлоод цаашдаа энэ эрчээ алдалгүй тасралтгүй хөгжиж, манлайлагч байхыг нийт бие бүрэлдэхүүнд захиад дараах үүрэг чиглэлийг өгсөн юм.

Цэргийн алба хаагч бүр шинэчлэл, өөрчлөлтийг өөрөөсөө эхэлж, эрхэлсэн ажилдаа эзэн нь байж, ажлын гүйцэтгэлийг өндөр түвшинд чанартайгаар зохион байгуулах,

болон боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарах,

Мөн Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг шинэчлэхийн зэрэгцээ шинэлэг инновацыг нэвтрүүлж үйлдвэрлэл, судалгааны ажлыг

тайлагнасан ЗХЖШ-ын нийт бие бүрэлдэхүүнд баяр хүргэж Монгол Улсын төр засаг, БХЯ-наас өгсөн үүрэг даалгаврыг чанартай сайн гүйцэтгэхийг захиж амжилт хүслээ.

Ө.НАСАНТОГТОХ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-11	-21

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.462	3.467
EUR	3.676	3.690
CNY	491	493
RUB	48.60	50
JPY	25.90	26,20
KRW	2.68	2.71

ЗУРХАЙ



2022.12.23 / БААСАН ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 30

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН ГАХАЙ САР
ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР

УС ЗАСУУЛБАЛ:

Эрлэг лугаа учирна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.40-17.02

Барилдлага:

Идэр
ШҮТЭН БАРИЛДАГА:
Сэрэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 660,617,552

Эдгэрсэн

Нийт: 633,428,931

Нас барсан

Нийт: 6,681,660

Цаг үе, үйл явдал

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

Батлан хамгаалах яам, Шинжлэх ухааны академи хоорондын хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах ёслол өнөөдөр боллоо.

Тус арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ШУА-ийн Ерөнхийлөгч, Монгол Улсын Төрийн шагналт, ШУ-ны гавьяат зүтгэлтэн, академич Д.Рэгдэл, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах, БХЯ-ны ТЗУГ-ын дарга хурандаа С.Ванчинхүү, ШУА-ийн Эрдэм шинжилгээ, төлөвлөлтийн хэлтсийн дарга, доктор С.Баянсан болон бусад албаныхан оролцлоо.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Одоогоос хоёр жилийн өмнө Төрийн захиргааны төв байгууллагуудаас анх удаа ШУА-тай салбар дундын харилцаа, тэр дундаа батлан хамгаалахын эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмийн бодлогын зөвлөлүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлэхээр харилцан тохиролцож, хамтран ажиллах санамж бичгийг байгуулж байсан. Хэдийгээр өнгөрсөн хоёр жилийн хугацаанд цар тахлын нөхцөл байдал хурцдаж, улс даяараа хөл хорионд орсон боловч



ШУА-тай хамтраад төлөвлөсөн ажлуудаа хэрэгжүүлэн ажлын уялдаа холбоог бий болгож чадсан. Мөн судалгааны ажлын чиглэлээр эрдэмтэд нэгдэж эхэлсэн нь тун авуштай байлаа. Өнөөдөр бид үргэлжлүүлэн цаашид хамтран ажиллахаар санамж бичгээ дахин байгууллаа.

Батлан хамгаалах салбарын хувьд мэдлэг оюун,

инновацид суурилсан зэвсэглэл техникийн шинэчлэлийг хийх, цэргийн технологийн шинэчлэлийг эхлүүлэн үйлдвэрлэгч, бүтээн байгуулагч байх зорилтыг тавин ажиллаж байгаа. Энэ ажилд ШУА-ийн эрдэмтдийн баг, хамт олны дэмжлэг чухал үүрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэж байна" гэсэн юм.

Тэгвэл ШУА-ийн Ерөнхийлөгч Д.Рэгдэл "Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд төлөвлөсөн ажлаа хийснээс гадна бидний хамгийн гол ололт бол хоёр талдаа байгаа оюуны болон материаллаг нөөцүүдээ мэдэж авсан. Үүний үр дүнд өнөөдөр үзэглэж буй хамтын ажиллагааны санамж бичигт маш тодорхой ажлуудыг төлөвлөн тусгалаа. Бид өнөөдөр энэхүү гэрээнд гарын үсэг зурж байгаа боловч төлөвлөсөн ажлууд маань хэдийнээ эхэлчихсэн. Өнөөдөр дэлхий дахины нөхцөл байдал таатай биш байгаа ч аливаа улсын аль ч салбарын хөгжил гэдэг шинжлэх ухаанд суурилах нь улам бүр тодорхой болж байна" хэмээгээд батлан хамгаалах салбарын нийт хамт олонд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөлөө.

Тус санамж бичгийн гол зорилго нь Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас батлан гаргасан шинжлэх ухаан, технологи, инновацын тухай хууль, эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд хамтарсан судалгаа явуулах, сургалт, судалгааны ажлыг нягт уялдуулах, харилцан мэдээлэл, санал солилцох, хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэх, цаашдын зорилтыг тодорхойлох зэрэг асуудлыг шийдвэрлэхэд оршиж буй юм.

ТӨРИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДАРГА НАРЫН ХАМТАРСАН ХУРАЛ БОЛЛОО



Төрийн байгууллагуудын ажиллагааны 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2023 оны төлөвлөгөөний төслийн тухай танилцуулах хурал өнөөдөр ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдааны

цэргийн нэгдсэн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2023 оны төлөвлөгөөний төслийн тухай танилцуулах хурал өнөөдөр ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдааны

хэлтсийн алба хаагчид оролцлоо.

ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба энэ үеэр "Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс болон бусад хууль эрх зүй, баримт бичгийн дагуу төрийн цэргийн байгууллагуудын харилцан ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлт, бэлэн байдал үүрэг гүйцэтгэл зэрэг үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зорилгоор ЗХЖШ-ын тайван цагийн бүтцэд Нэгдсэн ажиллагааны төлөвлөлтийн хэлтсийг 2020 оны 12 дугаар сард байгуулж, төрийн цэргийн болон төрлийн цэргийн командлал, удирдах газрын холбогч, төлөвлөлтийн мэргэжилтнүүдийг анх 2021 оноос томилон ажиллуулж байна. Төрийн цэргийн байгууллагуудын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны уялдаа холбоог нэмэгдүүлэх зорилгоор "Төрийн цэргийн байгууллагуудын нэгдсэн ажиллагааны 2022 оны төлөвлөгөө"-г энэ оны гуравдугаар сарын 30-ны өдөр баталж, та бид хамтран хэрэгжүүлээ. Дээрх журамд заасны дагуу

төрийн цэргийн байгууллагуудын нэгдсэн ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, дараа жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэх байгууллагуудын дарга нарын анхны хамтарсан хуралдаанд та бид өнөөдөр оролцож байна" гэлээ. Үргэлжлүүлэн ЗХЖШ-ын АУГ-ын дарга бригадын генерал С.Дашзэвэг 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2023 оны төлөвлөгөөний төслийг танилцуулсан юм.

Мөн хуралдааны үеэр хэлэлцсэн асуудлыг 2023 оны төлөвлөгөөний төсөлдөө тусгаж, хэрэгжилтийг нь хангах, эхний хагас жилийн гүйцэтгэлд байгууллагуудын Ажиллагааны удирдлагын нэгжүүдийн удирдлагын түвшинд үнэлгээ, дүгнэлт өгч, удирдлагыг мэдээллээр ханган, тодотгол хийж ажиллахаар болов.

Хурлын төгсгөлд бригадын генерал С.Ганбямба төрийн цэргийн байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд тодорхой чиглэл өгсөн юм.


Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №43

РА ҮСГИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ
РА бол хатуу дэвсгэр үсэг юм. Монгол хэлнээ, үгийн эхэнд энэ үсэг ордоггүй. Бүтэц зурлагын хувьд, өмнө үзсэн ЖА, ЯА үсгийн адил, үндсэн зурлага нь шилбэт үсэг бөгөөд эрвээлжин шилбэтэй РА үсэг гэдэг. Бичих журмын хувьд, ЖА үсгийнхтэй яг адил зартиг буюу толгойтой шулуун шилбэ татаад, үзгээ салгаж зүүн талаас хөндлөн доош зураас татаж огтлолцуулан нуруутайгаа нийлүүлж РА үсгийг бүтээдэг.

Уншигч та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд ордог РА, РЭ, РИ, РО, РУ, РӨ, РҮ гэж аялгуулан дуудаж үе үсэг хэрхэн хувирч буйг нүдлэн тогтоогоорой.

Бичмэл тигээр:



Ц.ТОГОО:УЛСЫН ХЭМЖЭЭНД 220 ГАРУЙ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛСАН



Өнөөдөр буюу энэ сарын 23-ны өдөр Монгол цэргийн нэгдсэн холбооны нарын бичгийн дарга нар орон нутаг дахь салбар холбоодын үйл ажиллагааг эрчимжүүлэх, цаашдын зорилтыг тодорхойлох, хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээгээ дүгнэх зорилгоор цугларалтыг зохион байгууллаа.

Цугларалтад Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх, МЦНХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Тогоо тэргүүтэй аймаг, нийслэлийн салбар холбоодын нарийн бичгийн дарга нар танхим болон цахим хосолсон хэлбэрээр хуралдсан юм.

Цугларалтыг нээж Ерөнхийлөгчийн зөвлөх, МЦНХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Тогоо хэлсэн үгэндээ тус төрийн бус байгууллага нь өнгөрсөн 3 жилийн хугацаанд хүүхэд, залууст эх оронч, үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх зорилгоор улсын хэмжээнд 220 гаруй томоохон ажил, арга хэмжээг амжилттай зохион байгуулан ажилласныг онцлоод эл байгууллагын ноён нуруу, ачааны хүндийг үүрч яваа салбар холбоодын нарийн бичгийн дарга нарт талархаж буйгаа илэрхийлсэн юм.

Үргэлжлүүлэн нийт бие бүрэлдэхүүнд МЦНХ-ны ажлын албаны дарга Ж.Ванчинсүрэн, ЦЕГ-ын хурандаа Г.Арсланхуяг, МУСГЗ, доктор Ж.Цогтсугар, Монгол Улсын Ардын багш, доктор, хурандаа Г.Мягмаржав тэргүүтэй хүмүүс тус тусын сэдвээр лекц уншиж танилцуулав.

Сургалтын төгсөлд салбар холбоодод тулгамдаж буй асуудлуудыг тодотгож хамтын хүчээр шийдвэрлэх зорилгоор чөлөөт хэлэлцүүлгийг зохион байгуулж, бие бүрэлдэхүүн төлөөллүүд санал бодлоо солилцлоо.